



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 04 дугаар сарын 16 өдөр Дугаар 27

Хэрлэн сум

XXVII ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын цомхотгосон хурал 2020 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 10:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 97.3 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж, холбогдох үүрэг даалгаврын өгөв.

ХЭЛЭЛЦСЭН нь:

1.Гэр хорооллын айл өрхийн хог, хаягдлыг тээвэрлэх ажлыг зохион байгуулах ажлын төлөвлөгөө, шаардагдах зардал, хүн хүчний тооцоог танилцуулах талаар:

Хэрлэн сумын Засаг даргын орлогч О.Пүрэв-Очир

2.ХХААХҮЯ-наас ноолуурын талаар гаргасан бодлого, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний тухай:

Хүнс хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газрын дарга Ж.Алимаа

3.Дотоодын хүмүүнлэгийн тусламжийн зарцуулалтын мэдээлэл, байгууллагуудаас Аймгийн Онцгой комисст ирүүлсэн санал:

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа Г.Нармандах

4.Ой, хээрийн түймрийн өнөөгийн нөхцөл байдал авч хэрэгжүүлж байгаа ажлын талаар:

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа Г.Нармандах

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Онцгой комиссын гишүүн П.Бат-Өлзий,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах нарт:

1.1.Гэр хорооллын айл, өрхийн хог, хаягдлыг тээвэрлэх ажилд шаардлагатай ковш, хүнд оврын техник хэрэгслийг дайчлахад дэмжлэг үзүүлэх, хяналт тавьж ажиллахыг,

1.2.Гэр хороололд амьдардаг төрийн албан хаагч нарт харьяа багийн нутаг дэвсгэрт нь хог, хаягдлыг тээвэрлэх хуваарьтай өдөр нь 1 өдрийн цалинтай чөлөө олгож тус ажилд дэмжлэг үзүүлэх ажиллах тухай албан бичгийг агентлагын дарга нарт хүргүүлэхийг,

Хоёр. Хүнс хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газрын дарга,

Онцгой комиссын гишүүн Ж.Алимаа,

Сүмдын Засаг дарга нарт:

2.1.Хүнс хөдөө аж ахуйн яамнаас ноолуурын талаар гаргасан бодлого, шийдвэр, аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газраас авч хэрэгжүүлж буй арга хэмжээний тухай мэдээллийг иргэд, олон нийтэд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр шуурхай хүргэхийг,

2.2.Ноолуур худалдан авалтын тухай мэдээ, тайланг 7 хоног тутам аймгийн Онцгой комиссийн даргад тайлагнаж байхыг,

Гурав.Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,

цагдаагийн хурандаа Т.Ганзориг-т:

3.1.Ноолуур худалдан авахтай холбоотой нийгмийн хэв журмыг сахиулах, замын постуудын хяналт, шалгалтын нэмэгдүүлэх, сумдын хэв журам хангуулдаг албан хаагч нарт үүрэг, чиглэл өгөхийг,

Дөрөв.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой

комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-т:

4.1.Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг сумдад зохион байгуулж ажиллах ажлын хэсэгт коронавируст халдвар (COVID-19)-өөс урьдчилан сэргийлэх зорилгоор амны даавуун хаалт 200 ширхэг, гар ариутгагч 3 ширхэгийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас олгохыг,

4.2.Гэр хорооллын айл өрхийн хог, хаягдлыг тээвэрлэх ажилд амны хаалт 400 ширхэг, нэг удаагийн конбинзон 15 ширхэг, нүдний шил 15 ширхэг, ариутгалын бодис шүршигч /автомакс/ 10 ширхэгийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас Хэрлэн суманд олгохыг,

4.3.Коронавируст халдвар (COVID-19)-ийн эрсдлээс урьдчилан сэргийлэх ажилд Тагнуулын газраас аймгийн Онцгой комиссын даргад ирүүлсэн хүсэлтийн дагуу ариутгалын бодис шүршигч /автомакс/ 1 ширхэгийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас олгохыг,

4.4.Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газраас аймгийн Засаг дарга, Онцгой комиссын даргад ирүүлсэн хүсэлтийн дагуу коронавируст халдвар (COVID-19)-өөс урьдчилан сэргийлэх зорилгоор Зүүн бүсийн ахмад настны асрамж, үйлчилгээний төвд ариутгал, халдваргүйтгэл хийх зардал 983,600 төгрөг, ариутгалын бодис шүршигч /автомакс/ 1 ширхэгийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас олгохыг,

4.5. 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдрөөс 05 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд коронавируст халдвар (COVID-19)-өөс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг зохион байгуулах аймгийн Онцгой комиссын Шуурхай штабын жижүүрийн үүргийг 24 цагаар гүйцэтгэж буй 2 албан хаагчийн хоолны зардал 960,000 төгрөгийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газарт олгохыг,


4.6.Коронавируст халдвар (COVID-19)-өөс урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд Бүсийн оношлогоо эмчилгээний төвөөс аймгийн Засаг дарга, Онцгой комиссын даргад ирүүлсэн албан бичгийн дагуу аж ахуйн нэгж байгууллага, иргэдээс хандив тусламжаар ирүүлсэн 25 нэр төрлийн 5,427,300 төгрөгийн бараа, материалыг зарцуулахыг эрхийг олгохыг,


4.7.Хилийн боомт бүхий Халхгол сум, Ялалт баг, Чулуунхороот сум, Матад сум, Газрын тосны XIX, XXI талбайд ажиллах ажлын хэсгийн шатахууны зардалд 806,400 төгрөг, томилолтын зардалд 1,590,000 төгрөг, нийт 2,396,400 төгрөгийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас олгохыг,

4.8.Баян-Уул сумын Онцгой комисс, хилийн боомт, Эрүүл мэндийн төвд N95 амны хаалт 90 ширхэг, ариутгалын бодис шүршигч /автомакс/ 3 ширхэг, Эрэнцав сумын Онцгой комисс, хилийн боомт, Эрүүл мэндийн төвд N95 амны хаалт 100 ширхэг, ариутгалын бодис шүршигч /автомакс/ 3 ширхэг, Халхгол сумын Онцгой комисс, хилийн боомт, Эрүүл мэндийн төв, Ялалт багт N95 амны хаалт 100 ширхэг, ариутгалын бодис шүршигч /автомакс/ 4 ширхэгийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас олгохыг,

4.9.Улсын Онцгой комиссоос Дорнод аймгийн Онцгой комисст N95 амны хаалт 10,000 ширхэгийг олгосныг тээвэрлэх зардал 150,000 төгрөгийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас Маск оёх ажлын хэсэгт олгохыг,

4.10.Гэр хорооллын айл өрхийн хог, хаягдлыг тээвэрлэх ажлыг нэгдсэн журмаар зохион байгуулахад шаардагдах нийт зардал 15,000,000 төгрөгийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас Хэрлэн суманд олгохыг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ КОМИССЫН
ДАРГА  М.БАДАМСҮРЭН

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА, ДЭД ХУРАНДАА  Д.БАТТУЛГА